

# ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ-ХОХИРОГЧ ХАМГААЛАЛ

**M**онгол Улсад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2004 оны 5 дугаар сард батлагдаж, 2005 оны 1 дүгээр сарын 1-ээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн.

Төрөөс хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой зарим заавар, журмыг батлан мөрдүүлж, хохирогчдыг хамгаалан байрлуулах үйлчилгээг мэргэшсэн байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж байна. Мөн

цагдаагийн байгууллагын дэргэд түр хамгаалах байр ажиллуулж, эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээ бий болгосон зэрэг бодлого болон үйл ажиллагааны хүрээнд эхлүүлсэн нааштай алхмуудыг дурдах нь зүйтэй. Гэвч гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хамгаалал нь тулгамдсан асуудал хэвээр байна.

## ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ

Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг жилээс жилд өссөн төдийгүй, улам харгис хэрцгийй, ноцтой хэлбэрт шилжиж байна.

Хууль байгаа ч хийдэл ихтэй, бусад хуультайгаа уялдаагүй, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн зохицуулалт дутмаг зэргээс хохирогчийг хамгаалж чадахгүй байна.

Өнөөгийн эрх зүйн зохицуулалтаар гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцдоггүй бөгөөд иргэний маргаан эсхүл захиргааны жижиг зөрчилд тооцож байна.

## КЕЙС, БАРИМТ, ТАЙЛБАР

Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 2013 онд өмнөх оноос 2.6 дахин, хүчирхийлэлд өртсөн хохирогчдын тоо 3.5 дахин өсчээ.

Сүүлийн 5 жилд гэр бүлийн хүчирхийллийн улмаас 61 хүн амь насаа алджээ.

5 гэр бүл тутмын нэг нь гэр бүлийн хүчирхийллийн шалтгаанаар гэрлэлтэй цуцлуулж байна.

5 хохирогч тутмын нэг нь л цагдаагийн байгууллагад хандаж байна.

2013 оны 5-р сарын 04-ний шөнө эцэг нь 4 настай хүүхдээ заазуурдсан хэрэг бүртгэгдсэн. Тэрээр 2012 оноос хойш хэрэг болдог өдөр хүртэлх хугацаанд нийт 10 удаа эрүүлжүүлэгдэж, Захиргааны хариуцлагын тухай хуулиар 5 удаа баривчлагдаж, торгуулж байжээ.

2013 оны 12-р сарын 10-ны өдөр 21 настай бүсгүй найз залуудаа зодуулсны улмаас бүх эрхтэн нь няцарч, цөс нь хагарч, харамсалтайгаар амь насаа алдсан. Энэ бүсгүй цагдаагийн байгууллагад хандсан ч туслалцаа авч чадсангүй.

2012 оны 4-р сард 22 настай хохирогч Г нь нөхөртөө 12 удаа хутгалуулж амиа алдсан. Тэрээр цагдаа, шүүхийн байгууллагад өөрийгөө хамгаалуулахаар удаа дараа хандсан ч туслалцаа авч чадаагүй.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөнөө нотлох үүргийг хохирогчид өөрт нь ногдуулж байна. Энэ төрлийн хэрэг ихэнх тохиолдолд нотлох баримтгүйгээс хэрэгсэхгүй болдог.

Хүчирхийлэл үйлдэгчид хулээлгэж буй хариуцлага нь оновчгүй, хохирогчийг давхар хохироож байна.

Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарласан шүүхийн шийдвэрийг хэн, ямар журмаар, хэрхэн биелүүлэх, хэрэгжилтэд нь яаж хяналт тавих талаарх хуулийн зохицуулалт өнөөг хүртэл огт байхгүйгээс энэ төрлийн шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байна.

Хохирогчийг хэн, хэрхэн хамгаалах, үйлчилгээг хаанаас, яаж үзүүлэх процедур, механизм нь тодорхойгүй байна.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч гэмт хэрэг үйлдэх аргыг сонгож байна.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч орон гэргүй болох нь түгээмэл байгаа ч энэ чиглэлийн тусгай хөтөлбөр байхгүй.

Төлбөрийн чадваргүй хохирогчид хууль, эрх зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн орчин байхгүй.

Сүүлийн 1 жилд гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хуулийн байгууллагад “худал мэдүүлэг өгсөн” хэрэгт татагдсан 5 тохиолдол бүртгэгдсэн байна.

Хүчирхийлэл үйлдэгчид Захиргааны хариуцлагын тухай хуулиар торгох, баривчлах, согтуу бол эрүүлжүүлэх байранд аваачих зэрэг арга хэмжээ авдаг бөгөөд энэ зардлыг ихэвчлэн хохирогч барагдуулдаг. Энэ нь жилд дунджаар 400000 төгрөг (200 гаруй ам.доллар) болж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 10 жилийн хугацаанд хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах ердөө 54 шүүхийн шийдвэр гарсан боловч нэг нь ч биелэгдээгүй.

Хэдийгээр хамгаалах байрууд нээгдэж, гэрч хохирогчийг хамгаалах алба ажиллаж эхэлсэн боловч салбар хоорондын зохицуулалтгүй, байгууллагуудын уялдаагүйгээс үйлчилгээ нь үр дүнд хүрэхгүй байна.

Байнгын хүчирхийлэл, дарамтын улмаас хүчирхийлэл үйлдэгчийнхээ амийг хөнөөсөн 38 эмэгтэй хорих ял эдэлж байна. Эдгээр эмэгтэйчүүдийн 32.3 хувь нь гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаа талаараа хуулийн байгууллагад удаа дараа хандаж туслалцаа хүсч байжээ.

Асрамж, халамжийн байгууллагад амьдарч байгаа 3 хүүхэд тутмын нэг нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас орон гэрээсээ дайжсан байна.

Төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагчид үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хууль Монгол Улсад байгаа боловч хохирогчид зориулагдсан хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн орчин байхгүй байна.

#### МОНГОЛЫН ХҮНИЙ ЭРХИЙН ТББ-УУДЫН ФОРУМААС ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА:

1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг шинэчлэх, сайжруулах, энэ хүрээнд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг нэн даруй хамгаалах, үйлчилгээ үзүүлэх үр дүнтэй механизмыг бий болгох;
2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг бусад хуультай уялдуулах;
3. Гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцож, хүчирхийлэл үйлдэгчид оногдуулах ял шийтгэлийн оновчтой хувилбарыг бий болгох;
4. Хохирогчоос аливаа тортгуй, төлбөр, хураамж гаргуулдаг зохицуулалтыг халах;
5. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах, нөхөн төлбөр олгох тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх;
6. Төлбөрийн чадваргүй хохирогчдод үзүүлэх үнэ төлбөргүй хууль зүйн үйлчилгээг бий болгох.